



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 16 өдөр

Дугаар 4/80


Хужирт сум

Хязгаарлалтын дэглэм тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3, 23 дугаар зүйлийн 23.5 дахь заалт, аймгийн Засаг даргын 2020 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн “Зоонозын өвчнөөс нийтийн эрүүл мэндийг хамгаалах хамтарсан салбар зөвлөл байгуулах тухай” А/147 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лабораторийн 2023 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 23-3459 дугаартай шинжилгээгээр тус сумын Шивээт 4 дүгээр багийн иргэн Раднаагийн Лхагвасүрэнгийн 6 үхрээс нь бруцеллёз өвчний эсрэг биет илэрсэн тул сумын Мал эмнэлгийн тасгийн саналыг үндэслэн 2023 оны 05 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн 6 сарын хугацаатай хязгаарлалтын дэглэм тогтоосугай.
2. Хязгаарлалтын дэглэм тогтоосон бүсэд зохион байгуулалтын арга хэмжээ авч, уг өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх зааврыг хангуулах, бруцеллёз өвчин илэрсэн малыг дулааны аргаар нядалгаанд оруулах ажлыг зохион байгуулж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн дарга (Б.Ичинхоролцэвэлмаа), дэглэм тогтоогдсон өрхийн малчдыг бруцеллёз өвчний тандалт шинжилгээнд хамруулахыг Эрүүл мэндийн төвийн Уламжлалтын их эмч (Ц.Ундрахбаяр) нарт тус тус үүрэг болгосугай.
3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Дэмбэрэл)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ

622301159

D:Alban bichig;Zahiramj 2023